

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ "Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага" Түргэвчилсэн судалгаа

2022 оны 6-р сар



© З.Эрдэнэ

Агуулга

Удиртгал ба аргачлал	1
Мэдээллийн дүн шинжилгээ.....	2
1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм.....	2
1.2 Ирсэн иргэд.....	3
1.3 Явсан иргэд.....	3
1.4 Хөдөлмөр эрхлэлт.....	4
1.5 Санхүүгийн нөхцөл байдал.....	5
1.6 Тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал.....	6
1.7 Үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц.....	10
1.8 Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж.....	14
1.9 Тээвэр, замын хөдөлгөөний нөхцөл байдал.....	15
1.10 Хүүхэд болон боловсрол.....	16

Удиртгал ба аргачлал

Удиртгал

Дүүргийн түвшний энэхүү тайланд 2022 оны 3-р сард Улаанбаатар хотын хэмжээнд хүн ам, шилжилт хөдөлгөөн, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шуурхай үнэлгээнд тусгагдсан үндсэн болоод сэдэвчилсэн бүх чиглэлийн тойм мэдээллийг багтаасан болно.

Энэхүү тайлан нь Чингэлтэй дүүргийн хэмжээнд найман үндсэн сэдвийг хамарсан судалгааг багтаасан; тухайлбал, хүн амын суурь тоон үзүүлэлт, хүн ам зүй, ирсэн болон явсан иргэд (шилжилт хөдөлгөөн), хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд ба аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, хүүхэд болон боловсрол гэх мэт. Мэдээллийг дүүргийн нутаг дэвсгэр, хүний нөөц, засаг захиргааны нэгжийн харилцааны талаарх мэдлэг өндөртэй мэдээлэл нэгтгэгчид болох хэсгийн ахлагч нартай ярилцлага хийх замаар олж авсан.

Энэхүү судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын дэлгэрэнгүй тайлангаас авч үзнэ үү.

Аргачлал

Энэхүү тайланд ОУШХБ-ын Шилжих хөдөлгөөнийг тандах матриц (ДТМ)-ийн нэгжээс боловсруулсан хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан болно.

Судалгаанд хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан Улаанбаатар хотын хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн түвшинд хэсгийн ахлагч нараас мэдээллийг цуглуулав. Хэсгийн ахлагч нар иргэдтэй ярилцах, ажиглалт хийх болон өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан, харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан тоон мэдээллийг нягтлах, баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөсөн юм. Хэсгийн ахлагч нарыг хүн амын суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхэд ба боловсрол гэсэн найман үндсэн сэдвийг багтаасан судалгааны асуулгыг бөглөхийг хүссэн юм.

Хэсгийн ахлагч нар Кобо программ хамгамжаар дамжуулан тоон мэдээллийг гар утас эсвэл таблет, компьютер ашиглан бөглөж илгээсэн. Хэсгийн ахлагч нарыг ДТМ судалгааны аргачлал, судалгааны асуулга, түүнийг нөхөхтэй холбоотой танхимын сургалтад бүрэн хамруулсан. Түүнчлэн ДТМ-ийн баг мэдээлэл цуглуулах явцад үүссэн аливаа асуулт, асуудалд цаг тухайд нь хариу өгч бэлэн байдалд ажилласан юм.


Өгөгдөл оруулах үйл явц албан ёсоор хаагдмагц ДТМ-ийн баг бүрэлдэхүүн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн бөгөөд өгөгдөл оруулахад гарч болзошгүй алдаа, тоон мэдээллийн зөрүү, давхардал зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийн хяналтын шатанд чанарын баталгаажуулалтын шалгалтыг хийсэн. Өгөгдөлтэй холбоотой аливаа асуудал илэрсэн тохиолдолд ДТМ-ийн баг тодруулга авахаар хэсгийн ахлагч нартай утсаар холбогдож тоон мэдээллийг тодруулж, баталгаажуулсан байна. Бүх хяналт, шалгалтыг хийж дууссаны дараа мэдээлэлд дүн шинжилгээ хийх үе шатанд шилжсэн. Бүх судалгааны үр дүнг хэсгийн түвшинд дүн шинжилгээ хийж, дараа нь дүүргийн болон хотын хэмжээнд нэгтгэн дүгнэв. Иймээс дүүрэг, хотын түвшинд энэхүү тайланд тусгагдсан аливаа үр дүнг хэсгийн түвшинд ч авах боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй юм.

Хязгаарлагдмал байдал, судалгааны аргачлалын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын хэмжээний нэгдсэн тайлангаас үзнэ үү.




1. МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ- ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм



Хүн ам зүй (эзлэх хувь)




Үнэлгээ хийх үед (2022 оны 3-р сар) Чингэлтэй дүүрэгт 149,879 иргэн буюу 36,471 өрх бүртгэгдсэн байна. Үүнээс 49 хувь нь эрэгтэй, 51 хувь нь эмэгтэй байна. Хүн амын 33 хувь нь насанд хүрээгүй хүүхэд гэж бүртгэгдсэн бол 11 хувь нь 0-5 настай, 22 хувь нь 6-17 настай хүүхэд байна. Хүн амын 61 хувийг 18-65 насны насанд хүрэгчид, 6 хувийг өндөр настан (65-аас дээш насныхан) эзэлж байна.

Нийтдээ 2,825 хүн архаг хууч эсвэл хүнд өвчтэй (хүн амын 1,9%) хүн бүртгэгдсэн бол, 1,175 эмэгтэй (эмэгтэйчүүдийн 1,5%) жирэмсэн гэж бүртгэгджээ.

Чингэлтэй дүүрэг нь 19 хороо, 195 хэсэгтэй. Дүүргийн хүн амын 9 хувь нь оршин суудаг 17-р хороо хамгийн олон хүн амтай гэж бүртгэгдсэн бол дараа нь 12-р хороо (9%), 7-р хороо (8%) орсон байна.


Хүн ам зүйн тойм хүйсээр, хороогоор (эзлэх хувь)



1.2 Ирсэн иргэд²

2021 онд Чингэлтэй дүүрэгт нийт 2893 өрх буюу 9,185 иргэн ирсэн байна. 2021 онд Улаанбаатар хотод нийт ирсэн иргэдийн 7.7 хувь нь Чингэлтэйд бүртгэгдсэн бол тэдний хамгийн өндөр хувь нь 9-р хороонд (11%) байна. Тус дүүрэгт ирсэн гол шалтгаан нь гэр бүл (32%), дараа нь боловсрол (23%), эдийн засгийн (16%) шалтгаанууд байна.


Ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)




1.3 Явсан иргэд

2021 онд Чингэлтэй дүүргээс нийт 3,735 өрх буюу 13,713 иргэн явсан байна. 2021 онд Улаанбаатар хотын хэмжээнд нийт явсан иргэдийн 15.9 хувь нь Чингэлтэй дүүргээс гэж бүртгэгдсэн байна. Хамгийн өндөр хувь нь 9-р хороо (25%), удаалаад 10-р хороо (14%), 4-р хороо (14%) ноос тус тус явжээ. Ерөнхийдөө энэ дүүргээс нүүсэн (явсан) хамгийн чухал шалтгаан нь гэр бүлийн шалтгаан (32%) байв.

Явсан иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)



Ирсэн, явсан үндсэн шалтгаанууд (эзлэх хувь)




² Ирсэн иргэд гэдэг нь Улаанбаатар хотын дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран Улаанбаатар хотын аль нэг байршилд оршин суухаар ирсэн иргэн, айл өрхийг хэлнэ. Явсан иргэд гэдэг нь Улаанбаатар хотын аль нэг байршлаас явсан эсэхийг үл хамааран явсан иргэн, айл өрхийг хэлнэ.


1.4 Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Чингэлтэй дүүргийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар нь барилга (хэсгүүдийн 33%-д), дараа нь бөөний болон жижиглэнгийн худалдаа (30%), бусад (10%), үйлдвэрлэл (8%) байна. Барилгын ажил 12-р хороо (хэсгүүдийн 65%), 9-р хороо (хэсгүүдийн 60%), 16-р хороо (хэсгүүдийн 57%)-нд хамгийн түгээмэл хөдөлмөр эрхлэлтээр бүртгэгдсэн байна. Бөөний болон жижиглэнгийн худалдаа нь хөдөлмөр эрхлэлтийн хоёр дахь том салбар боловч тодорхой хороодод илүү төвлөрсөн байна. 10-р хорооны хэсгүүдийн 80 хувь, 2-р хорооны хэсгүүдийн 75 хувь, 8-р хорооны хэсгүүдийн 67 хувь худалдаа нь хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар болдог. 1-р хороо бол нэгэн ижил төрлийн хөдөлмөр эрхэлдэг бүс юм. Хэсгүүд 100 хувь төрийн удирдлага, батлан хамгаалах салбарт хөдөлмөр эрхэлдэг гэж бүртгэгдсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийн хамгийн түгээмэл салбар нь барилгын салбар байсан бөгөөд хэсгүүдэд 47,648 иргэн (дүүргийн хүн амын 32%) барилгын салбарт хөдөлмөр эрхэлж байна гэж бүртгэгдсэн байна. Мөн жижиглэнгийн худалдаа хөдөлмөр эрхлэлтийн зонхилох салбар байсан төдийгүй хэсгүүдэд 43,970 иргэн (дүүргийн хүн амын 29%) энэ салбарт хөдөлмөр эрхэлж байна.


Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар (хэсгийн эзлэх хувь)




Хөдөлмөр эрхлээгүй хүн ам (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь, хороогоор (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлэлтийн төрөл (хэсгийн эзлэх хувь)



Чингэлтэй дүүргийн хэмжээнд 18-64 насны 29,279 иргэн хөдөлмөр эрхлээгүй байгаа нь насанд хүрсэн хүн амын 32 хувийг эзэлж байна. Энэ дүүрэгт хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь хотын дунджаас (30%) хоёр пунктээр өндөр байна. Хөдөлмөрийн насны хүн амын талаас илүү хувь нь хөдөлмөр эрхлээгүй байгаа 8-р хороо (54%), түүнчлэн 11-р хороо (47%), 12-р хороо (45%)-нд хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь хамгийн өндөр байна. Тэдгээр гурван хороонд хөдөлмөрийн насны нийт 13,172 иргэн байгаагаас 6159 иргэн хөдөлмөр эрхэлдэггүй гэсэн мэдээлэл байна. Харин эсрэгээрээ хөдөлмөрийн насны хүн амын 98 хувь (3,073 хүнээс 2997 нь хөдөлмөр эрхэлдэг) хөдөлмөр эрхэлдэг 5-р хороонд хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь хамгийн бага, удаалаад 2-р хороо (95%), 1-р хороо (93%) байна. Тэдгээр гурван хороонд хөдөлмөрийн насны нийт 7120 иргэн байгаагаас 6,787 нь хөдөлмөр эрхэлдэг гэсэн мэдээлэл байна.

Чингэлтэй дүүргийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн төрлийн хувьд хэсгүүдийн 82 хувьд хувийн хэвшил, 10 хувьд хувиараа хөдөлмөр эрхлэлт, 6 хувьд төрийн байгууллагын ажил зонхилж байна. Чингэлтэй дүүрэгт Улаанбаатар хотын бусад дүүрэгтэй харьцуулахад хувийн хэвшлийн хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт хамгийн их байна. Мөн энд төрийн албаны ажил дундаж түвшингээс хамаагүй доогуур (хотын дунджаас есөн хувийн пунктээр бага) байгааг мэдээлсэн. Хувийн хэвшлийн салбарын хөдөлмөр эрхлэлт 2, 5, 8, 14, 17-р хороодын бүх хэсэгт байдаг гэж мэдээлжээ. 5 болон 2-р хороод дүүргийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр (98% ба 95%) байгаа гэж мэдээлсэн болохыг тэмдэглэх нь зүйтэй. 1-р хорооны бүх хэсэгт төрийн албаны хөдөлмөр эрхлэлт маш өндөр (93%) байна гэж мэдээлжээ.

1.5 Санхүүгийн нөхцөл байдал

Энэ хэсэгт орлогын бууралт болон хүнсэнд зарцуулах зардлын бууралттай холбоотой асуудлаар мэдээлэл нэгтгэгчдийн ажиглалтыг авч үзэх замаар төлбөрийн чадварыг судалсан болно.

Нийт Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байгаа хэсгүүдийн 3 хувьд нь мэдээлэгчид мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд өрхүүд хангалттай хоол хүнсгүй байна гэж санаа зовниж байгааг мэдээлсэн нь нийт 46,351 хүнд нөлөөлсөн байна. Энэ хувь нь хотын дундаж болох 29 хувиас бага зэрэг өндөр буюу хоёр пунктээр өндөр байна. 16-р хороо үүнд хамгийн их өртөж байгаа бөгөөд хэсгүүдийн 64 хувьд мэдээлэгчид хангалттай хоол хүнсгүй байгаа талаар санаа зовнил байгааг мэдээлжээ.

Хэсгүүдийн 37 хувийн мэдээлэгч нар мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд айл өрхүүд хүнсний хэрэглээгээ багасгасан тухай сонссон гэж мэдээлсэн нь нийт 55,366 хүнд нөлөөлсөн байна. Энэ хувь нь мөн хотын дундаж болох 34 хувиас бага зэрэг өндөр буюу гурван пунктээр өндөр байна. Хэсгүүдийн 75 хувьд мэдээлэгчид 7-р хороо хамгийн их өртөж байгаа бөгөөд айл өрхүүд хүнсний зардлаа бууруулж байгаа тухай сонссон тухай мэдээлсэн байна.

Хүнсний аюулгүй байдал (хэсгийн эзлэх хувь)


Хүнсний хэрэлээ хангалтгүй байгаад санаа зовних




Хүнсний хэрэглээгээ багасгасан



Сүүлийн 4 долоо хоногт орлого нь буурсан иргэд (хэсгийн эзлэх хувь)



Сүүлийн 4 долоо хоногт бүх орлогоо алдсан иргэд (хэсгийн эзлэх хувь)




Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дэх хэсгүүдийн 81 хувьд нь мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд нийт оршин суугчдын талаас бага хувь нь буюу бараг хэн ч орлого буураагүй гэж мэдээлжээ. Гэхдээ хэсгүүдийн 19 хувь нь оршин суугчдын тал буюу талаас илүү хувь нь орлогоо алдсан нь 30,119 хүнд нөлөөлсөн гэж мэдээлсэн. Хэсгүүдийн 85 хувьд нь мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд оршин суугчдын талаас бага хувь буюу бараг хэн ч орлогоо алдаагүй гэж мэдээлсэн байна. Гэхдээ хэсгүүдийн 15 хувь нь оршин суугчдын тал буюу талаас илүү хувь нь бүх орлогоо алдсан байсан нь 23,326 хүнд нөлөөлсөн хэмээн мэдүүлжээ.

1.6 Тулгамдаж буй асуудал болон аюулгүй байдал

Чингэлтэй дүүргийн хэмжээнд хамгийн тулгамдсан асуудлууд нь санхүү, эдийн засгийн тогтворгүй байдалтай холбоотой гэсэн байна. Хамгийн их мэдээлэгдсэн тулгамдсан асуудал бол орлого хангалтгүй (хэсгүүдийн 48 хувьд мэдээлсэн), дараа нь хэсгүүдийн хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь өндөр 6 айна (24%), мөн өр, зээл (12%) гэж бүртгэгджээ. 1, 11-р хороонд хамгийн тулгамдсан асуудал нь орлого хангалтгүй байгаа тухай иргэдийн санаа зовнил байсан бөгөөд үүнийг хэсгүүдийн 80 хувьд мэдээлжээ.

Тулгамдаж буй асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




Чингэлтэй дүүргийн хэмжээнд иргэдийн амьжиргаа, ажлын байр, орлого бий болгох боломж (23%), орон сууц (19%), эрүүл мэндийн үйлчилгээ, авто машины зогсоол (тус бүр 14%) зэрэг үйлчилгээг авахад хамгийн хүндрэлтэй байдаг гэж мэдээлжээ. 19-р хорооны хэсгүүдийн иргэдийн 55 хувьд амьжиргаа, ажлын байр, орлого бий болгох боломж байхгүй байгаа нь нэн тулгамдсан анхаарах асуудал байсан бол 13-р хорооны хэсгүүдийн 67 хувь нь орон сууцтай болох нь хамгийн их анхаарал хандуулах асуудал байна гэж мэдээлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй гол тулгамдсан асуудал нь тусгай зориулалтын эмнэлгийн тусламж үйлчилгээ дутмаг (42%), дараа нь гудамж, цэцэрлэгт хүрээлэн, барилга байгууламжид аюулгүй нэвтрэх дэд бүтэц хангалтгүй (31%) гэсэн байна.


Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгамдаж буй асуудал (хэсгийн эзлэх хувь)



Хүндрэлтэй байдаг үйлчилгээ (хэсгийн эзлэх хувь)



Аюулгүй байдал, хороогоор Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш сайн




Аюулгүй байдлыг хөндсөн асуудал гарсан эсэх (хэсгийн эзлэх хувь)



13%

Аюулгүй байдлыг хөндсөн асуудал сүүлийн 4 долоо хоногт гарсан


Аюулгүй байдлыг хөндсөн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




1.7 Дэд бүтэц, үйлчилгээ

УС

Усны хэрэглээгүй байгаа хүмүүс (хэсгийн эзлэх хувь %)




Устай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

Цахилгааны хэрэглээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Цахилгааны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ХООЛ, ХҮНС

Хүнсний бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ОРОН БАЙР

Орон байрны хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Орон байртай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




1.7 Дэд бүтэц, үйлчилгээ

ХҮНСНИЙ БУС ЗҮЙЛС

Хүнсний бус бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнсний бус бүтээгдэхүүнтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ИНТЕРНЭТ

Интернэтэд холбогдоогүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Интернэтийн хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




УХААЛАГ УТАС

Ухаалаг утас ашигладаггүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)



Ухаалаг утасны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




1.8 Ногоон байгууламж

Мэдээлэл нэгтгэгчдээс өөрийн хэсгийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанарт нэгээс тав хүртэл, нэг нь маш муу, тав нь маш сайн гэсэн үнэлгээ өгөхийг хүссэн. Нийтдээ Чингэлтэй дүргийн бүх төрлийн ногоон байгууламжийн чанар нийслэлийн дунджаас доогуур байв. Өрхийн ногоон байгууламжийн чанар 1-р хэсэгт (4.0) хамгийн өндөр, 3-р хэсэгт (1.0) хамгийн бага байв. Хувийн хэвшлийн ногоон байгууламжийн чанар 1-р хэсэгт хамгийн өндөр (3.6), 10-р хэсэгт (1.8) хамгийн бага байв. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн чанар дахин 1-р хэсэгт хамгийн өндөр (3.8), 9, 10-р хэсэгт хамгийн бага (хоёулаа 1.7) байна.


Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар
(хэсгийн эзлэх хувь %)

Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш


Өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар



Хувийн хэвшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар (хэсгийн эзлэх хувь %)	Өрхийн ногоон байгууламж	Хувийн хэвшлийн ногоон байгууламж	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж
Хороо #1	4.0	3.8	3.6
Хороо #2	3.0	3.3	2.5
Хороо #3	1.0	3.0	2.0
Хороо #4	2.3	3.5	2.3
Хороо #5	2.6	2.8	2.6
Хороо #6	2.9	3.3	3.4
Хороо #7	2.5	2.0	2.0
Хороо #8	2.3	1.9	2.4
Хороо #9	2.0	1.7	2.1
Хороо #10	1.9	1.7	1.8
Хороо #11	2.8	2.5	2.5
Хороо #12	2.2	2.1	2.4
Хороо #13	3.2	2.8	3.6
Хороо #14	2.2	1.9	1.9
Хороо #15	2.8	2.3	2.3
Хороо #16	2.4	2.5	2.6
Хороо #17	2.1	1.9	2.3
Хороо #18	2.5	2.3	2.3
Хороо #19	2.6	2.5	2.3

1.9 Зам тээвэр ба хөдөлгөөн


Хувийн тээврийн хэрэгсэлгүй өрх (хэсгийн эзлэх хувь)



Тээврийн үндсэн аргууд (хэсгийн эзлэх хувь)



Замын хөдөлгөөнтэй холбоотой үндсэн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Автобус, микро автобус нь зонхилох тээврийн хэрэгсэл (хэсгүүдийн 52%) болох Чингэлтэй дүүрэгт замын хөдөлгөөнтэй холбоотой гарч болзошгүй бүх асуудал бүртгэгдсэн байна. Дүүргийн хэмжээнд замын хөдөлгөөний хамгийн хүндрэлтэй асуудал нь авто машины зогсоол дутмаг (23%), дараа нь хүүхэд тоглох талбай дутмаг (19%) байна. 1, 2, 4-р хорооны бүх хэсгүүдэд авто машины зогсоол дутмаг байгаа тухай мэдээлсэн байна.





© Ү.Одбаяр

1.10 Хүүхэд ба боловсрол


Чингэлтэй дүүргийн хэмжээнд 0-5 насны 3,947 хүүхэд цэцэрлэгт хамрагдаагүй (тухайн насны хүн амын 24%), 6-17 насны 1,100 хүүхэд (тухайн насны хүн амын гурван хувь) сургуульд хамрагдаагүй байна. Дүүргийн хэмжээнд цэцэрлэгт хамрагдаагүй 0-5 насны хүүхдүүдийн түвшин хотын дунджаас зургаан пунктээр бага байна. 0-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдаагүй түвшин 14-р хороонд (44%) хамгийн өндөр, харин 6-17 насны хүүхдүүдийн боловсролд хамрагдаагүй түвшин 18-р хороонд (22%) хамгийн өндөр байв.

Хүүхдүүдийн ерөнхий нөхцөл байдлыг илүү өргөн хүрээнд судлахын тулд мэдээлэл нэгтгэгчдээс хүүхдүүдэд тулгардаг үндсэн асуудал хэсгийн нутаг дэвсгэр дээр хэр байгаа талаар асуусан. Чингэлтэй дүүрэг дэх хэсгүүдийн 46 хувь нь боловсролын талаар ямар ч асуудал гараагүй гэж хариулсан бол 19 хувь нь анги танхимын хүртээмж муу, ачаалал их байгаа гэж хариулжээ. Дүүргийн хэмжээнд хүүхдүүдтэй холбоотой хамгийн их бүртгэгдсэн хоёр асуудал бол хүүхдийн Хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх секц, дугуйлан дутмаг (хэсгүүдийн 43%), интернэт болон гэрээсээ сурхад шаардлагатай бусад хэрэглүүр байхгүй (16%) гэж мэдээлсэн юм.


Сургуульд хамрагдаагүй хүүхдүүд (хэсгийн эзлэх хувь)



Боловсролтой холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Хүүхдэд тулгамдаж буй асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийн агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн туршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, аюулгүй, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ дараах зорилтын хүрээнд хамтран ажилладаг. Үүнд: Шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх; шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих; мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн сайхныг дээдлэх зэрэг болно.

Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томъёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Судалгааны аргачлал, арга зүй, дүн шинжилгээ, тайланг загварчлах ажлыг ОУШХБ-ын ДТМ хариуцсан ОУ-ын зөвлөх Витторио Бруни, дотоодын зөвлөх Ганбатын Гэрэлтогтох, туслалцаагаар болор-эрдэний Маналцогзолын хамт боловсруулсан болно. Судалгааны асуулгыг ОУШХБ-ын баг, НЗДТГ-ын оролцоотойгоор боловсруулсан байна. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ийг дэмжих багийн удирдлагуудын техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.